

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙН МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛ

Энэхүү Протоколд оролцогч улсууд,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд тунхагласан зарчимд нийцүүлэн, хүн төрөлхтөний гэр бүлийн бүх гишүүний угаас заяасан нэр төр, тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь дэлхий дахинд эрх чөлөө, шударга ёс, энх тайвныг хангах үндэс болно гэж үзэж,

Хүүхдийн эрхийн тухай конвенц (цаашид “Конвенц” гэх)-ийн оролцогч улсууд уг конвенцид заасан эрхүүд нь тухайн оролцогч улсын харьяаллын хүрээнд байгаа хүүхэд бүрт аливаа төрлийн алагчилалгүйгээр, тухайн хүүхдийн эсхүл түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний, угсаатны буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, төрсөн буюу бусад байдлаас үл харгалзан үйлчилнэ гэдгийг хүлээн зөвшөөрч буйг *тэмдэглэж*,

Хүний бүх эрх, тулгуур эрх чөлөө нь түгээмэл, хуваагдашгүй, харилцан шалтгаалсан, харилцан хамаарсан шинжтэй болохыг *дахин нотолж*,

Хүүхэд нь эрх эдлэх субъект мөн бөгөөд нэр төр болон өсөн хөгжиж буй чадвар боломжтой гэсэн байдлыг *нь мөн дахин нотолж*,

Хүүхдийн онцгой бөгөөд бусдаас шалтгаалах байдал нь тэднийг эрхээ зөрчигдсөн тохиолдолд эрх зүйн хамгаалалт авахад бодит саад бэрхшээл үүсгэж болохыг *хүлээн зөвшөөрч*,

Энэхүү Протокол нь хүүхэд эрхээ зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргах боломж олгож үндэсний болон бүс нутгийн механизмыг бэхжүүлэн, нэмэлт болно гэж үзэж,

Хүүхдийн эрхийг зөрчсөн тохиолдолд эрх зүйн хамгаалалт авахад хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд харгалзан үзэх нь зүйтэй бөгөөд эрх зүйн ийм хамгаалалт нь бүх шатанд хүүхдийн мэдрэмж, хэрэгцээнд нийцсэн журам хэрэгтэй болохыг харгалзан үзэх нь зүйтэй гэдгийг *хүлээн зөвшөөрч*,

Оролцогч улсууд дотоодын түвшинд эрх зүйн үр дүнтэй хамгаалалт авах боломжийг эрх нь зөрчигдсөн хүүхдэд олгосон үндэсний зохих механизмыг хөгжүүлэн бүрдүүлэхийг *урамшуулан дэмжиж*,

Хүүхдийн эрхийг хөхиүлэн дэмжиж, хамгаалах үүрэг бүхий хүний эрхийн үндэсний байгууллага, холбогдох бусад мэргэшсэн байгууллага энэ талаар чухал үүрэг гүйцэтгэж болохыг *эргэн санаж*,

Үндэсний ийм механизмыг бэхжүүлэн, нэмэлт болох, Конвенцийн болон зохих тохиолдолд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг болон хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг түүний Нэмэлт протоколуудын хэрэгжилтийг цаашид

эрчимжүүлэхийн тулд Хүүхдийн эрхийн хороо (цаашид “Хороо” гэх)-нд энэхүү Протоколд тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэх боломжийг өгөх нь зохимжтой гэж үзэж,

Дор дурьдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов:

I ХЭСЭГ ЕРӨНХИЙ ЗААЛТУУД

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХОРООНЫ ЭРХ ХЭМЖЭЭ

1. Энэхүү Протоколд оролцогч улс нь энэхүү Протоколд заасан Хорооны эрх хэмжээг хүлээн зөвшөөрнө.
2. Хороо нь энэхүү Протоколд оролцогч улсын хувьд түүний нэгдэж ороогүй баримт бичигт заасан эрх зөрчигдсөн асуудлаар тухайн улсын талаар эрх хэмжээгээ хэрэгжүүлэхгүй.
3. Хэрэв мэдээлэл нь энэхүү Протоколд оролцогч биш улстай хамааралтай бол Хороо түүнийг хүлээж авахгүй.

2 ДУГААР ЗҮЙЛ ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГТ УДИРДЛАГА БОЛГОХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

Энэхүү Протоколоор олгосон чиг үүргийг биелүүлэхдээ Хороо нь хүүхдийн дээд ашиг сонирхлын зарчмыг удирдлага болгоно. Хороо нь мөн хүүхдийн эрх, санал бодлыг харгалзах бөгөөд чингэхдээ хүүхдийн санал бодолд хүүхдийн нас, төлөвшсөн байдлыг үндэслэн зохих дүгнэлт өгнө.

3 ДУГААР ЗҮЙЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

1. Хороо нь энэхүү Протоколоор олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мөрдөх үйл ажиллагааны горимоо батална. Чингэхдээ хүүхдийн мэдрэмж, хэрэгцээнд нийцсэн журмыг хангах зорилгоор ялангуяа энэхүү Протоколын 2 дугаар зүйлийг харгалзан үзнэ.
2. Хороо нь үйл ажиллагааны горимдоо хүүхдийг төлөөлж буй этгээд хүүхдийг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэрэгслийг тусгах бөгөөд хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэхгүй гэж үзсэн бол мэдээллийг авч үзэхээс татгалзаж болно.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

1. Оролцогч улс нь түүний хуулийн харьяалалд байгаа хувь хүмүүс энэхүү Протоколын дагуу Хороонд мэдээлэл хүргүүлсэн буюу Хороотой хамтран ажилласныхаа төлөө хүний эрхийн зөрчил, хэрцгий хандах, айлган сүрдүүлэх үйлдэлд өртөхгүй байх явдлыг хангах чиглэлээр зохих бүх алхмыг хийнэ.

2. Тухайн аливаа хувь хүн буюу хэсэг хүн нь хэн болох талаархи мэдээллийг тэдний шууд өгсөн зөвшөөрөлгүйгээр нийтэд задруулахгүй.

II ХЭСЭГ МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ЖУРАМ

5 ДУГААР ЗҮЙЛ ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Мэдээллийг тухайн улс нэгдэн орсон дор дурьдсан баримт бичгүүдэд заасан аливаа эрхийг тухайн оролцогч улс зөрчсөний улмаас хохирогч болсон гэж үзэж тухайн оролцогч улсын хуулийн харьяалалд хамаарах хувь хүн буюу хэсэг хүн өөрөө эсхүл тэднийг төлөөлж хүргүүлж болно:

(a) Конвенц;

(b) Конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Нэмэлт протокол;

(c) Конвенцийн Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг нэмэлт протокол.

2. Мэдээллийг өөр хувь хүн буюу хэсэг хүнийг төлөөлж хүргүүлж буй тохиолдолд тухайн хүнээс ийм зөвшөөрлийг авсан байна. Зарим үндэслэл бүхий онцгой тохиолдолд мэдээлэл гаргагч нь төлөөлж буй хүмүүсийн зөвшөөрөлгүйгээр Хороонд хандаж болно.

6 ДУГААР ЗҮЙЛ ТҮР АРГА ХЭМЖЭЭ

1. Мэдээллийг хүлээн авсны дараа түүнд туссан асуудлаар шийдвэр гаргахаас өмнө Хороо нь мэдээлэлд туссан зөрчлийн хохирогч буюу хохирогч нарт учирч болох, засч болшгүй хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс онцгой тохиолдолд шаардлагатай байж болох түр арга хэмжээг яаралтай авахыг хүссэн хүсэлтийг тухайн оролцогч улсад хүргүүлж болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу Хороо эрх үүргээ хэрэгжүүлж буй тохиолдолд үүнийг тухайн мэдээллийг хүлээж авах боломжтой эсэх талаар эсхүл мэдээлэлд туссан асуудлаар шийдвэр гаргасан гэж үзэхгүй.

7 ДУГААР ЗҮЙЛ ХҮЛЭЭЖ АВАХ БОЛОМЖТОЙ ЭСЭХ

Хороо нь мэдээллийг дараахь тохиолдолд хүлээн авах боломжгүй гэж үзнэ:

(a) Мэдээллийг хүргүүлэгчийн нэр байхгүй;

(b) Мэдээллийг бичгээр хийгээгүй;

(c) Мэдээлэл нь ийм мэдээлэл хүргүүлэх эрхийг урвуулан ашиглаж хийгдсэн эсхүл Конвенц болон/буюу түүний Нэмэлт протоколуудын заалтад нийцээгүй;

(d) Тухайн асуудлыг Хороо нэгэнт шалгасан эсхүл хэрэг шийдвэрлэх олон улсын өөр ажиллагаа буюу зохицуулалтын журмын дагуу шалгаж ирсэн буюу шалгаж буй;

(e) Дотоодын эрх зүйн бүх хамгаалалтыг хэрэглэж дуусгаагүй. Эрх зүйн хамгаалалт хэрэглэх асуудал үндэслэлгүйгээр удааширч буй буюу үр дүнтэй тусламж үзүүлэх магадлалгүй тохиолдолд энэ дүрэм үйлчлэхгүй;

(f) Мэдээлэл нь илэрхий үндэслэлгүй буюу хангалттай нотолгоогүй;

(g) Мэдээлэлд туссан үйл баримт нь энэхүү Протокол тухайн оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө үүсэн, гэхдээ тухайн үйл баримт уг хугацаанаас хойш үргэлжилж байгаагаас бусад тохиолдолд;

(h) Мэдээллийг дотоодын эрх зүйн бүх хамгаалалтыг хэрэглэж дууссанаас хойш нэг жилийн дотор хүргүүлээгүй, гэхдээ мэдээлэл хүргүүлэгч нь тухайн мэдээллийг дээрх хугацааны хязгаарт хүргүүлэх боломжгүй байсныг нотлон харуулж чадахаас бусад тохиолдолд.

8 ДУГААР ЗҮЙЛ МЭДЭЭЛЛИЙГ ДАМЖУУЛАХ

1. Хороо тухайн оролцогч улсыг зааж өчихгүйгээр мэдээллийг хүлээж авах боломжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд Хороо нь энэхүү Протоколын дагуу хүргүүлсэн аливаа мэдээллийг тухайн оролцогч улсын анхааралд аль болох түргэн нууцаар хүргүүлнэ.

2. Оролцогч улс нь тухайн асуудлын талаар болон хэрэв эрх зүйн хамгаалалтаар хангасан бол тэр талаар бичгээр тайлбар буюу мэдэгдэл хийж Хороонд хүргүүлнэ. Оролцогч улс нь хариугаа зургаан сарын дотор аль болох түргэн хүргүүлнэ.

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ НӨХӨРСГӨӨР ЗОХИЦУУЛАХ

1. Хороо нь асуудлыг Конвенц болон/буюу түүний нэмэлт протоколуудад заасан үүргийг хүндэтгэх үндсэн дээр нөхөрсгөөр зохицуулах үүднээс холбогдох талуудад туслах үйлчилгээг үзүүлнэ.

2. Хорооны ивээл дор нөхөрсгөөр зохицуулахаар тохиролцсоноор энэхүү Протоколын дагуу мэдээллийг авч үзэх хэргийг хаана.

10 ДУГААР ЗҮЙЛ МЭДЭЭЛЛИЙГ АВЧ ҮЗЭХ

1. Хороо нь энэхүү Протоколын дагуу хүлээж авсан мэдээллийг хүргүүлсэн бүх бичиг баримтын хүрээнд аль болох түргэн авч үзнэ, чингэхдээ уг бичиг баримтыг холбогдох талуудад дамжуулсан байна.

2. Хороо нь энэхүү Протоколын дагуу хүлээж авсан мэдээллийг шалгахдаа хаалттай хуралдаан хийнэ.

3. Хороо түр арга хэмжээ авах хүсэлт гаргасан бол тухайн мэдээллийг авч үзэхээ түргэвчилнэ.

4. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг зөрчсөн хэмээх мэдээллийг шалгахдаа Хороо нь тухайн оролцогч улс Конвенцийн 4 дүгээр зүйлийн дагуу хийсэн алхмын үндэслэлийг авч үзнэ. Чингэхдээ Хороо нь тухайн оролцогч улс Конвенцид заасан эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэхийн тулд авч болох бодлогын хэд хэдэн арга хэмжээ авч болно гэдгийг харгалзан үзнэ.

5. Мэдээллийг шалгасны дараа Хороо нь тухайн мэдээллийн талаархи санал бодлоо, хэрэв зөвлөмж байгаа бол тэр зөвлөмжийнхөө хамт, холбогдох талуудад ямарваа сааталгүйгээр дамжуулна.

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ МӨРӨӨР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

1. Оролцогч улс нь Хорооны санал бодлыг, хэрэв зөвлөмж байгаа бол тэр зөвлөмжийн хамт, зохих ёсоор авч үзэж Хорооны санал бодол ба зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний талаархи мэдээлэл зэргийг агуулсан хариуг Хороонд бичгээр хүргүүлнэ. Оролцогч улс хариугаа зургаан сарын дотор аль болох түргэн хүргүүлнэ.

2. Хороо нь түүний санал бодол буюу зөвлөмжийн хариуд эсхүл хэрэв нөхөрсгөөр зохицуулахаар тохиролцсон бол уг тохиролцоог хэрэгжүүлэхийн тулд тухайн оролцогч улсын хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар нэмэлт мэдээлэл өгөхийг, түүний дотор хэрэв Хороо зохимжтой гэж үзсэн бол Конвенцийн 44 дүгээр зүйл, Конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протоколын 12 дугаар зүйл, эсхүл Конвенцийн Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг нэмэлт протоколын 8 дугаар зүйлийн дагуу тухайн улсын дараагийн тайланд тусгахыг оролцогч улсад санал болгож болно.

12 ДУГААР ЗҮЙЛ УЛС ХООРОНД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ

1. Энэхүү Протоколд оролцогч улс аль нэг оролцогч улс нөгөө оролцогч улсыг тухайн улс нэгдэн орсон дор дурдсан баримт бичгүүдийн аль нэгний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна гэж үзэн мэдэгдэж буй мэдээллийг хүлээж авч, авч үзэх талаархи Хорооны эрх хэмжээг хүлээн зөвшөөрч буйгаа хэдийд ч зарлан мэдэгдэж болно:

(a) Конвенц;

(b) Конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протокол;

(c) Конвенцийн Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг нэмэлт протокол.

2. Хороо нь ийм мэдэгдэл хийгээгүй оролцогч улстай холбоотой мэдээлэл эсхүл ийм мэдэгдэл хийгээгүй оролцогч улсаас хүргүүлсэн мэдээллийг хүлээж авахгүй.

3. Хороо нь асуудлыг Конвенц болон түүний Нэмэлт протоколуудад заасан үүргийг хүндэтгэх үндсэн дээр асуудлыг нөхөрсгөөр шийдвэрлэх үүднээс холбогдох оролцогч талуудад туслах үйлчилгээг үзүүлнэ.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хийсэн мэдэгдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулах бөгөөд тэрээр мэдэгдлийн хувийг оролцогч бусад улсад тараана. Мэдэгдлийг Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар хэдийд ч буцаан татаж болно. Ийнхүү буцаан татсан нь энэ зүйлийн дагуу нэгэнт хүргүүлсэн мэдээлэлд туссан асуудлыг авч үзэхэд саад болохгүй; холбогдох оролцогч улс шинэ мэдэгдэл хийхээс бусад тохиолдолд мэдэгдлийг буцаан татах тухай мэдэгдлийг Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээж авснаас хойш аливаа оролцогч улсын мэдээллийг энэ зүйлийн дагуу хүлээж авахгүй.

III ХЭСЭГ НЯГТЛАН ШАЛГАХ ЖУРАМ

13 ДУГААР ЗҮЙЛ НОЦТОЙ БУЮУ СИСТЕМТЭЙ ЗӨРЧЛИЙГ НЯГТЛАН ШАЛГАХ ЖУРАМ

1. Хэрэв Хороо Конвенц эсхүл хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг буюу хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг түүний Нэмэлт протоколуудад заасан эрхийг аль нэг оролцогч улс ноцтойгоор буюу системтэйгээр зөрчиж буйг харуулсан найдвартай мэдээлэл авсан бол Хороо нь уг мэдээллийг шалгах талаар хамтран ажиллахыг, мөн түүнчлэн тухайн мэдээлэлтэй холбогдуулан саналаа ямарваа сааталгүйгээр өгөхийг тухайн оролцогч улсад санал болгоно.

2. Холбогдох оролцогч улсын өгч болох аливаа санал болон түүнд байгаа аливаа бусад найдвартай мэдээллийг харгалзан үзэж Хороо нь нэг буюу хэд хэдэн гишүүнээ томилж нягтлан шалгах ажиллагаа явуулж, Хороонд яаралтай тайлагнах үүрэг өгч болно. Үндэслэл байгаа бөгөөд тухайн оролцогч улсын зөвшөөрөл байгаа тохиолдолд нягтлан шалгах ажиллагаанд тухайн улсын нутаг дэвсгэрт очих үүрэг багтаж болно.

3. Ийм нягтлан шалгах ажиллагааг нууцаар явуулах бөгөөд уг ажиллагааны бүх шатанд тухайн оролцогч улсын зүгээс хамтран ажиллахыг шаардана.

4. Ийм нягтлан шалгах ажиллагааны дүгнэлтийг шалгасны дараа Хороо нь уг дүгнэлтийг холбогдох оролцогч улсад аливаа санал, зөвлөмжийн хамт ямарваа сааталгүйгээр дамжуулна.

5. Оролцогч улс нь Хорооноос ирүүлсэн дүгнэлт, санал, зөвлөмжийг хүлээж авснаас хойш зургаан сарын дотор аль болох түргэн өөрийн саналаа Хороонд хүргүүлнэ.

6. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу явуулсан нягтлан шалгах ажиллагаа дууссаны дараа Хороо нь энэхүү Протоколын 16 дугаар зүйлд заасан тайланд уг ажиллагааны үр дүнгийн тойм тайланг холбогдох оролцогч улстай зөвлөлдсөний дараа оруулахаар шийдвэрлэж болно.

7. Оролцогч улс бүр энэхүү Протоколд гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орохдоо 1 дэх хэсэгт жагсаасан зарим буюу бүх баримт бичигт заасан эрхтэй холбогдуулан энэ зүйлд заасан Хорооны эрх хэмжээг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа зарлан мэдэгдэж болно.

8. Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдэл хийсэн аливаа оролцогч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар энэ мэдэгдлээ хэдийд ч буцаан татаж болно.

14 ДҮГЭЭР ЗҮЙЛ НЯГТЛАНШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ МӨРӨӨР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

1. 13 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан зургаан сарын хугацаа дууссаны дараа хэрэв шаардлагатай бол Хороо нь холбогдох оролцогч улсыг энэхүү Протоколын 13 дугаар зүйлийн дагуу явуулсан нягтлан шалгах ажиллагааны хариуд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээнийхээ талаар мэдээлэх саналыг тавина.

2. Хороо нь 13 дугаар зүйлийн дагуу явуулсан нягтлан шалгах ажиллагааны хариуд тухайн оролцогч улсын хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар нэмэлт мэдээлэл өгөхийг, түүний дотор хэрэв Хороо зохимжтой гэж үзсэн бол Конвенцийн 44 дүгээр зүйл, Конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протоколын 12 дугаар зүйл, эсхүл Конвенцийн Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг нэмэлт протоколын 8 дугаар зүйлийн дагуу тухайн улсын дараагийн тайланд тусгахыг оролцогч улсад санал болгож болно.

IV ХЭСЭГ ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

15 ДУГААР ЗҮЙЛ ОЛОН УЛСЫН ТУСЛАЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

1. Хороо нь мэдээлэл, нягтлан шалгах ажиллагаатай холбоотой бөгөөд техникийн зөвлөгөө буюу туслалцаа хэрэгтэйг дурдсан санал бодол буюу зөвлөмжөө хэрэв тухайн оролцогч улс эдгээр санал бодол буюу зөвлөмжийн талаар санаа, саналтай бол тэдгээрийн хамт Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага, сан, хөтөлбөр, эрх бүхий бусад байгууллагад тухайн оролцогч улсын зөвшөөрөлтэйгээр дамжуулж болно.

2. Мөн оролцогч улсууд Конвенц болон/буюу түүний Нэмэлт протоколуудаар хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэх талаар оролцогч улсууд ахиц гаргахад нь дээрхбайгууллагуудтуслахад хувь нэмэр оруулж болох олон улсын арга хэмжээг хэрэглэх нь зохимжтой эсэх талаар эдгээрбайгууллагатус бүрийн эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргахад нь тусалж болох аливаа асуудал энэхүү Протоколын дагуу авч үзэж буй мэдээллүүдээс гарч ирвэл Хороо нь

үүндтэдгээр байгууллагын анхаарлыг тухайн оролцогч улсын зөвшөөрөлтэйгээр хандуулж болно.

16 ДУГААР ЗҮЙЛ ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙД ТАЙЛАГНАХ

Хороо нь Конвенцийн 44 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн дагуу Ерөнхий Ассамблейд хоёр жил тутам өргөн барьдаг тайландаа энэхүү Протоколын дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа тоймыг багтаана.

17 ДУГААР ЗҮЙЛ НЭМЭЛТ ПРОТОКОЛЫГ ТҮГЭЭХ БОЛОН НЭМЭЛТ ПРОТОКОЛЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭХ

Оролцогч улс бүр насанд хүрэгч болон хүүхдэд нэгэн адил, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст, тохиромжтой бөгөөд идэвхтэй аргаар хүрч болох хэлбэрээр энэхүү Протоколыг өргөн нийтэд мэдүүлэх, түгээх, түүнчлэн Хорооны санал бодол, зөвлөмжийн талаархи, ялангуяа тухайн оролцогч улсад холбогдох асуудлаархи санал бодол, зөвлөмжийн талаархи мэдээллийг олж авахад нь дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ.

18 ДУГААР ЗҮЙЛ ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ, СОЁРХОН БАТЛАХ, НЭГДЭН ОРОХ

1. Энэхүү Протокол нь Конвенц эсхүл түүний эхний хоёр Нэмэлт протоколын аль нэгэнд гарын үсэг зурсан, түүнийг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон аливаа улсын хувьд гарын үсэг зурахад нээлттэй байна.
2. Энэхүү Протоколыг Конвенц эсхүл түүний эхний хоёр Нэмэлт протоколын аль нэгийг соёрхон баталсан эсхүл түүнд нэгдэж орсон аливаа улс соёрхон батлана. Соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.
3. Энэхүү Протокол нь Конвенц эсхүл түүний эхний хоёр Нэмэлт протоколын аль нэгийг соёрхон баталсан эсхүл түүнд нэгдэж орсон аливаа улсын хувьд нэгдэн ороход нээлттэй байна.
4. Нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаар нэгдэн орсон нь хүчинтэй болно.

19 ДҮГЭЭР ЗҮЙЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

1. Энэхүү Протокол нь арав дахь соёрхон баталсан тухай батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.
2. Арав дахь соёрхон баталсан тухай батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулснаас хойш энэхүү Протоколыг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон улс бүрийн хувьд өөрийн соёрхон баталсан тухай батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ

хадгалуулснаас хойш гурван сарын дараа энэхүү Протокол хүчин төгөлдөр болно.

20 ДУГААР ЗҮЙЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛСНООС ХОЙШ ГАРАХ ЗӨРЧИЛ

1. Хороо нь гагцхүү энэхүү Протокол хүчин төгөлдөр болсноос хойш Конвенц эсхүл түүний эхний хоёр Нэмэлт протоколын аль нэгэнд заасан аливаа эрхийг оролцогч улс зөрчсөн асуудлаар эрх хэмжээгээ хэрэгжүүлнэ.

2. Хэрэв аль нэг улс энэхүү Протоколд хүчин төгөлдөр болсных нь дараа нэгдэн орвол тухайн улсын Хорооны өмнө хүлээх үүрэг зөвхөнэнэхүү Протокол тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш Конвенц эсхүл түүний эхний хоёр Нэмэлт протоколын аль нэгэнд заасан аливаа эрхийг зөрчсөн асуудалд хамаарна.

21 ДҮГЭЭР ЗҮЙЛ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

1. Оролцогч аливааулсэнэхүү Протоколд нэмэлтөөрчлөлт оруулахсаналгаргаж, саналааНэгдсэнҮндэстнийБайгууллагынЕрөнхийнарийнбичгийн даргад хүргүүлж болно. Ерөнхийнарийнбичгийн даргасанал болгосон нэмэлт өөрчлөлтийг оролцогч улсуудад мэдээлж, уг саналыг авч үзэж шийдвэр гаргах зорилгоор оролцогч улсуудынхурал хийхийг зөвшөөрч буй эсэхээ мэдэгдэхийг хүснэ. Ийнхүү мэдээлсэн эс хойш дөрвөн сарын дотор оролцогч улсуудын гуравны нэгээс доошгүйнхурал хийхийг зөвшөөрвөл Ерөнхий нарийн бичгийн дарга хурлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээлд ор зарланхуралдуулна. Хурал доролцож санал өгсөн оролцогч улсуудын гуравны хоёрын олонхийн саналаар батлагдсан нэмэлт өөрчлөлтийг Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий Ассамблейд батлуулахаар, түүний дараа оролцогч бүх улсад хүлээн зөвшөөрүүлэхээр илгээнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хурлаар болон Ерөнхий Ассамблейгаар батлагдсан нэмэлт өөрчлөлтийг хурлаар баталсан өдөр байсан тооны оролцогч улсын гуравны хоёр нь хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг хадгалуулснаас хойш гуч дахь өдөр уг нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болно. Түүнээс хойш нэмэлт өөрчлөлт нь аливаа оролцогч улсын хувьд хүлээн зөвшөөрсөн тухай өөрийн баримт бичгээ хадгалуулснаас хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно. Нэмэлт өөрчлөлтийг зөвхөн түүнийг хүлээн зөвшөөрсөн оролцогч улс заавал дагаж мөрдөнө.

22 ДУГААР ЗҮЙЛ ЦУЦЛАХ

1. Оролцогч аливаа улс энэхүү Протоколыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдсэний үндсэн дээр хэдийд ч цуцалж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

2. Ийнхүү цуцлах нь цуцлалт хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө 5 буюу 12 дугаар зүйлийн дагуу хүргүүлсэн аливаа мэдээлэл эсхүл 13 дугаар зүйлийн

дагуу үүсгэсэн нягтлан шалгах аливаа ажиллагааны хувьд энэхүү Протоколын заалтуудыг үргэлжлүүлэн хэрэглэхэд саад болохгүй.

23 ДУГААР ЗҮЙЛ ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ХАДГАЛАХ БА МЭДЭГДЭХ ҮҮРЭГ

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Протоколын хадгалагч байна.
2. Ерөнхий нарийн бичгийн дарга дараахь мэдээллийг бүх улсад өгнө:
 - (a) Энэхүү Протоколд заасны дагуу гарын үсэг зурсан, соёрхон баталсан, нэгдэн орсон тухай;
 - (b) Энэхүү Протокол болон 21 дүгээр зүйлийн дагуу түүнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрийн тухай;
 - (c) Энэхүү Протоколын 22 дугаар зүйлийн дагуу цуцлалт хийсэн тухай.

24 ДҮГЭЭР ЗҮЙЛ ХЭЛ

1. Энэхүү протоколын англи, араб, испани, орос, франц, хятад хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй байх бөгөөд түүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын архивт хадгалуулна.
2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Протоколын баталгаат хуулбарыг бүх улсад хүргүүлнэ.